



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 8/2017

Улаанбаатар хот

Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь

1. "Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа алба, салбаруудын агаарын навигацийн болон нисэх буудлуудын үйлчилгээний бэлэн байдлыг шалгах навигацийн үзлэг зохион байгуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалтын "Навигацийн үзлэгийг "Шалгах хуудас"-ыг ашиглан гүйцэтгэж, дүнг гаргахдаа "Шалгах хуудас"-ын асуулгын тооноос хамааран тодорхойлно. 100-150 асуулгатай бол 4.1.1-ээр, 50-100 асуулгатай бол хавсралт 4.1.2-оор, 10-50 асуулгатай бол хавсралт 4.1.3-аар тус тус үнэлнэ.", 4.1.1, 4.1.2, 4.1.3 дахь заалтуудыг тус тус хүчингүй болгож, 4.3 дахь заалт дахь "ажлын хэсгийн дарга" гэснийг "комиссын бүрэлдэхүүн" гэж өөрчилж, "Нисэх буудлын үйл ажиллагааг оновчтой төлөвлөж хэрэгжүүлсэн төлөвлөгөөний хэрэгжилт, ажлын байрны тодорхойлолтын дагуу ажил үүргээ гүйцэтгэсэн, удирдах дээд байгууллагаас хүргүүлсэн албан даалгавар болон үүрэг даалгаврын биелэлтийг хангасан орон нутгийн нисэх буудлуудын дарга, ажилтнуудад комиссын дарга үнэлэлт, дүгнэлт өгнө." гэж тус тус нэмэлт өөрчлөлт оруулсугай.

2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2017 оны А/559 дүгээр тушаалаар батлагдсан "Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа алба, салбаруудын агаарын навигацийн болон нисэх буудлуудын үйлчилгээний бэлэн байдлыг шалгах навигацийн үзлэг зохион байгуулах журам"-д өөрчлөлт орсонд тооцсугай.

ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН